

Монгол Улсын Хууль зүйн яам
ХУУЛЬ ЗҮЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

230

2014 оны 12 дугаар
сарын 5 өдөр

Дугаар А/215/421

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал /Х.Өлзийбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Амарзаяа/-т даалгасугай.
4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 135/256 дугаар тушаалаар хамтран баталсан "Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ТЭМҮҮЖИН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Н.УДВАЛ

Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын
2014 оны /2. дугаар сарын .25.-ны өдрийн
А/215/421 дугаар тушаалын хавсралт

ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрүү, иргэн, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад шинжлэх ухааны онол, арга зүйд тулгуурлан анагаах ухаан, биологийн холбогдолтой асуудлаар шүүх эмнэлгийн шинжилгээ (цаашид "шинжилгээ" гэх) хийхэд энэхүү журмыг баримтлана.

1.2. Шинжээч эмч (цаашид "шинжээч" гэх) нь үндсэн, төрөлжсөн мэргэжил эзэмшсэн байх бөгөөд хууль дээдлэх, хүний эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хараат бус байх, нууцыг хадгалах, шинжилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй хийх зарчмыг баримтлана.

1.3. Шинжилгээ хийхдээ Шүүхийн шинжилгээний тухай, Эрүүгийн байцаан шийтгэх, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр. Шинжилгээний төрөл

2.1. Шинжилгээ нь анхдагч, нэмэлт, дахин гэсэн төрлүүдтэй байх ба эдгээрийг дангаар болон бүрэлдэхүүнтэйгээр хийж болно.

2.2. Дараах тохиолдолд шинжилгээг бүрэлдэхүүнтэй хийнэ. Үүнд:

2.2.1. онц хүнд хэрэг болон маргаантай тохиолдолд;

2.2.2. эмч, эмнэлгийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагаатай холбоотой тохиолдол;

2.2.3. шарил шинжлэх тохиолдол;

2.2.4. эхийн эндэгдлийн тохиолдол.

2.3. Дахин шинжилгээг бүрэлдэхүүнтэйгээр хийх бөгөөд бүрэлдэхүүний тоо сондгой байна.

Гурав. Шинжилгээний баримт бичиг, түүний хөтлөлт

3.1. Шинжилгээний баримт бичгийг төрийн албан хэрэг хөтлөх журмын дагуу Монгол хэлээр ойлгомжтой, байгууллагын батлагдсан хэвлэмэл хуудсан дээр хэвлэнэ.

3.2. Шинжлүүлж буй хүн монгол хэл мэддэггүй, эсвэл хараагүй, дүлий, сэтгэцийн эмгэгтэй байвал орчуулагч, хэлмэрч, харгалзан дэмжигч нарыг байлцуулан шинжилгээг хийх ба орчуулагч, хэлмэрчийг шинжилгээнд оролцуулахыг шинжээч томилсон хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч хариуцна.

3.3. Орчуулах боломжгүй гадаад үг, нэр томъёог олон улсын нэршлээр хэрэглэнэ.

3.4. Шинжилгээний баримт бичиг нь удиртгал, шинжилгээ, дүгнэлт гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

3.5. Удиртгал хэсэгт дор дурдсан мэдээллийг тусгана:

3.5.1. шинжилгээ хийсэн газар, огноо, цаг хугацаа;

3.5.2. шинжилгээ хийх болсон үндэслэл;

3.5.3. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн талаарх мэдээлэл;

3.5.4. шинжилгээ хийсэн шинжээчийн талаарх мэдээлэл (овог нэр, мэргэжил, эрдмийн болон мэргэжлийн зэрэг, цол, албан тушаал);

3.5.5. шинжилгээний объектын тухай мэдээлэл (овог нэр, нас, хүйс, хаяг, хэргийн материалын дугаар эсвэл шинжлэгдэхүүнийг заах);

3.5.6. шинжилгээ хийхэд байлцсан хүмүүсийн талаарх мэдээлэл;

3.5.7. санаатай худал дүгнэлт гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг сануулсан тэмдэглэл;

3.5.8. хэргийн байдлын талаарх товч мэдээлэл.

3.6. Шинжилгээний хэсэгт дор дурдсан мэдээллийг тусгана:

3.6.1. шинжлүүлж буй хүний зовиур, шинжилгээний үед илэрсэн өөрчлөлтийн тухай мэдээлэл;

3.6.2. үзлэг шинжилгээний цаг хугацааны тухай тэмдэглэл дүрслэл оношлогооны болон эмнэл зүйн, лабораторын үндсэн ба төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө зэргийг оролцуулна;

3.6.3. цогцос шинжилсэн бол төгсгөлд нь шүүх эмнэлгийн онош бичнэ.

3.7. Дүгнэлтийн хэсэгт дор дурдсан мэдээллийг тусгана:

3.7.1. шинжээч томилсон захирамж, тогтоолд тавигдсан асуулт бүрт хариулах;

3.7.2. шинжилгээ дууссан огноо.

3.8. Шинжээч нь хуулийн болон мэргэжлийн бус хүрээний асуудал хөндөж дүгнэлт гаргахгүй.

3.9. Шинжээчид асуулт тавигдаагүй боловч шинжилгээний явцад илэрсэн, тухайн хэрэг шийдвэрлэхэд мэргэжлийн зүгээс боломжит асуудлыг шинжээчийн санаачилгаар дүгнэлтэд тусгаж болно.

3.10. Нэмэлт шинжилгээ хийсэн бол анхны дүгнэлт гаргасан шинжээч нь өөрийн дүгнэлтийн дугаарыг дурдаж, нэмж хийсэн шинжилгээний хариуг хавсарган дүгнэлт гаргаж болно.

3.11. Шинжээч шинжилгээний бичиг баримтаа хянан, гарын үсэг зурж, эмчийн болон байгууллагын тэмдгээр баталгаажуулснаар хүчинтэйд тооцно.

3.12. Шинжээч дүгнэлтийг хоёр хувь үйлдэж тухайн албаны албан тушаалтанд хүлээлгэн өгөх ба уг албан тушаалтан нэг хувийг шинжээч томилсон этгээдэд, үлдэх хувийг архивт хадгална.

3.13. Шинжээчийн дүгнэлтийг энэхүү журамд зааснаар батлагдсан загварын дагуу бичих ба өөрөөр үйлдэхийг хориглоно.

Дөрөв. Шинжээчийн үйл ажиллагаа

4.1. Шинжээч нь хэргийн газрын үзлэг, мөрдөн байцаалтын туршилтад оролцож, хүн, цогцос, шарил, эд мөрийн баримт болон хэргийн материалд тулгуурлан шүүх эмнэлгийн бүх төрлийн шинжилгээ хийж, шаардагдах хялбар сорилуудыг тавина.

4.2. Шинжээч нь зөвхөн эрх бүхий этгээдийн шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамжаар шинжилгээ хийж дүгнэлт гаргана.

4.3. Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан үндэслэлээр шинжээч нь шинжилгээ хийхээс татгалзаж болно.

4.4. Шинжээч нь хэргийн газрын үзлэгт оролцох, хүн, цогцос, биологийн эд мөрийн баримтад шинжилгээ хийх ба хэргийн материалд бүрэлдэхүүнтэйгээр шинжилгээ явуулж болно.

4.5. Шинжлэгдэхүүний эмгэгт байдлыг нотлох зорилгоор шүүх эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн шинжээч шинжилгээг хийнэ.

4.6. Шинжээч нь Шүүхийн шинжилгээний тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад хууль дүрэм, журамд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Тав. Шүүх эмнэлгийн шинжлэгдэхүүнүүдийг шинжлэх

5.1. Хүний биеийг шинжлэхэд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 28, 29 дүгээр зүйлийг баримтлана.

5.2. Цогцсыг шинжлэхэд дараах журмыг баримтална:

5.2.1. Шинжилгээг тусгай тоноглогдсон өрөө, тасалгаанд хийх гамшгийн нөхцөл үүссэн, эсхүл орон нутагт болон шарил шинжлэх зэрэг тохиолдолд тухайн нөхцөлд тохируулан хийх;

5.2.2.Шинжилгээний тэмдэглэлийг тухайн шинжилгээний явцад байлцаж буй эмнэлгийн мэргэжилтэн, бичээч, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын аль нэгээр бичүүлэх;

5.2.3.Цогцсын гавал, цээж, хэвлийн хөндийн эрхтнүүдийг заавал нэг бүрчлэн шинжлэх, ингэхдээ цээж, хэвлийн хөндийн агууламж, гялтангийн байдал, гадны биет, эрхтнүүдийн байрлалыг тэмдэглэж, дотор эрхтнүүдийг иж бүрдлээр нь гаргаж араас нь урагш, дээрээс нь доош чиглэлээр эрхтэн бүрийг хамруулан үзлэг хийж эрхтэн тус бүрийн доорх шинж чанарыг тусгасан тэмдэглэл хөтөлнө: Үүнд:

5.2.3.1.өнгө (үндсэн, суурь өнгө, туяарлаар ялгах);

5.2.3.2.хэлбэр;

5.2.3.3.тогтоц (хатуу, биелэг, зөөлөн, шавархаг, улбагар, хагас шингэн, хийрхэг г.м);

5.2.3.4.гадаргуу (толигор, барзгар, зангилаажсан, мөхлөгжсөн, жигд бус);

5.2.3.5.ирмэг (нимгэн, зузаан, мохоо, хурц);

5.2.3.6.хэмжээ (урт, өргө, зузааныг олон улсын Си системийн нэгжээр);

5.2.3.7.жин (олон улсын Си системийн нэгжээр);

5.2.3.8.цуллаг эрхтний цусан хангамж;

5.2.3.9.хөндийт эрхтний салст бүрхүүл болон дотор ханын байдал;

5.2.3.10.агууламж, гадны биет;

5.2.3.11.бүтэц (үе давхарга, дэлбэн, дэлбэнцэр, хэлтэн, хэлтэнцэр);

5.2.3.12.эмгэг өөрчлөлт;

5.2.3.13.гэмтэл түүний байрлал, шинж байдал;

5.2.3.14.яс, үе холбоос, мөч;

5.2.4.цогцосноос авах нэмэлт шинжилгээний дээжүүдийг лабораториудаас гаргасан зааврын дагуу авна;

5.2.5.эмгэг судлалын шинжилгээний явцад нас барахад хүргэсэн гадны нөлөө (гэмтэл), түүний шинж тэмдэг илэрвэл хуулийн байгууллага, тухайн эмнэлгийн захиргаанд мэдэгдэж, шинжээч эмчийг шинжилгээнд оруулах ба шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журмыг баримтлана.

5.2.6.цогцост шинжилгээ хийх явцад эд эрхтнээс шинжилгээний болон эрдэм шинжилгээ, сургалтын зорилгоор дээж авсан бол энэ тухайгаа шинжилгээний тэмдэглэлд тусгана;

5.2.7.цогцост шаардлагагүй зүслэг хийх, эд, эрхтнийг таслах, авахыг хориглоно;

5.2.8.цогцосыг шинжлэх үед эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр ар гэр, төрөл төрөгсдийн төлөөллийг байлцуулж болно.

5.3. Эд мөрийн баримтанд шинжилгээ хийхэд дараах зүйлийг баримтлана:

5.3.1.эд мөрийн баримтанд шүүх биологи, шүүх хими, шүүх эд эс, дүрс оношлогоо, эмнэлзүйн лаборатори, эмнэлэг криминалистикийн шинжилгээг шинжээч томилох эрх бүхий этгээдийн тогтоол, захирамжаар хийнэ.

5.3.2.эд мөрийн баримт нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-д заасан шаардлагыг хангасан байх ба шинжлэх зүйл бүрдэл болоогүй бол тэдгээрийг холбогдох байгууллага, хүмүүсээс шаардаж авах хүртэл шинжилгээг хойшлуулж болно.

5.3.3.шүүх эмнэлгийн төрөлжсөн лабораториудын үйл ажиллагааны стандартыг Шүүхийн шинжилгээний төв байгууллага баталж мөрдүүлнэ.

5.3.4.эд мөрийн баримт шинжлэх явцад бусад мэргэжилтнийг оролцуулах шаардлага гарвал шинжээч томилсон этгээдэд мэдэгдэж мэргэжилтэн, шинжээчийг томилуулна.

5.4.Эрүү, иргэн, захиргааны хэргийн материалыг үндэслэн шинжилгээ хийхэд дараах зүйлийг баримтлана:

5.4.1.шинжээч нь хавтаст хэргийн материалыг тогтоол, дагалдах материалын хамт, тусгай бүртгэлтэй хүлээн авч шинжилгээ хийх;

5.4.2.хэргийн материал нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-д заасан шаардлагыг хангасан байх;

5.4.3.шаардлагатай тохиолдолд хүний биед эмнэлгийн үзлэг хийх, нэмэлт шинжилгээ хийх, шарилыг шинжлэх зэрэг арга хэмжээ авах ба энэ тухайгаа шинжээч томилсон этгээдэд мэдэгдэж дээрх арга хэмжээг авах нөхцөлөөр хангуулах;

5.4.4.хавтаст хэргийн материалын нууцлал болон түүний бүрэн байдлыг шинжээч эмч хариуцна.

Зургаа. Дүгнэлт гаргах хугацаа

6.1.Шинжээчийн дүгнэлт гаргах хугацааг шинжилгээний шинжлэгдэхүүний төрөл, онцлог, цар хүрээг харгалзан шинжээч томилох эрх бүхий этгээд тогтооно.

6.2.Шинжээч нь тогтоол хүлээн авсанаас хойш доорх хугацаанд дүгнэлт гаргах чиглэл баримтлана.

6.2.1.хүний биед үзлэг хийсэн бол ажлын 3 хүртэл;

6.2.2.нэмэлт шинжилгээ хийсэн бол ажлын 5;

6.2.3.цогцос шинжилсэн бол ажлын 10;

6.2.4.эд эсийн болон нэмэлт шинжилгээ хийсэн эсхүл хэргийн материалаар шинжилгээ хийсэн бол ажлын 21;

6.2.5.лабораторийн нарийн шинжилгээ хийсэн бол ажлын 21;

6.2.6.шарил шинжилсэн бол ажлын 21 хоногт багтаан дүгнэлтийг гаргана.

6.3.Нэмэлт материал шаардагдах тохиолдолд хугацааг сунгаж болно.

6.4.Дүгнэлт гаргах хугацааг сунгах зайлшгүй шаардлагатай бол энэ тухай шинжээч томилсон этгээдэд урьдчилан мэдэгдэнэ.

Долоо. Бусад

7.1.Шүүх хуралдаанд шинжээчээр оролцсоны хөлсийг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон бусад хуульд заасны дагуу гаргана.

7.2.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----